БАТЛАВ
" ДИПЛОМАТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛЧИЛГЭЭГ
ЭРХЛЭХ ГАЗАР" ТӨҮГ-Н ЗАХИРАЛ

Б.ИЧИНХОРЛОО

## АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2022 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

| № | Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа | Үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Төсөв | Хүрэх түвшин, үр дүн | Хариуцах нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1. | Хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хариуцлагыг дээшлүүлэх | Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн ХАСУМ-ыг АТГ-т хүргүүлж, дүгнэлт гарсныг үндэслэн албан тушаалд томилох | 2022 онд | - | ХАСУМ хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилсон байна. | Захиргааны хэлтэс |
| | | Нийтийн албан тушаалтны ХАСУМ хянасан дүгнэлтийг олон нийтэд, нээлттэй, ил тод болгох, байгууллагын цахим хуудаст байршуулах | 2022 онд | - | Дүгнэлтүүд нээлттэй, ил тод мэдээлэгдсэн байна. | Захиргааны хэлтэс |
| 2. | Нийтийн албаны ёс зүйн үлгэрчилсэн дүрмийг дагаж мөрдөх, ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх, шалтгаан нөхцлийг тогтоох, арилгах, тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хэвшүүлэх | Төрийн албаны ёс зүй, байгууллагын Ёс зүйн дүрмийг албан хаагчдад сурталчлан таниулах, Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангуулах | 2022 онд | - | Ёс зүйн дүрмийг чанд сахиж, ажилтнуудын сахилга хариуцлага дээшилсэн байна. | Захиргааны хэлтэс, Санхүү, эдийн засгийн хэлтэс, Үйлчилгээ, ашиглалтын хэлтэс |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 3 | Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх арга хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх | Албан хаагчдын зүгээс гарсан авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг хүлээн авч шалгах тогтолцоог бүрдүүлж, гомдол мэдээлэл үндэслэл бүхий тохиодолд холбогдох байгууллагад хандаж шалгуулах арга хэмжээг тухай бүр авах | 2022 онд | - | Авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол гарсан тохиолдол бүрийг шалгадаг тогтолцоо бүрдсэн байна. | Дотоод аудитор |
| 4 | Эрсдэлд суурилсан төрийн хяналт шалгалт болон аж ахуйн нэгжийн дотоод хяналтыг бэхжүүлэх, хяналт шалгалтын 70 хувийг урьдчилан сэргийлэх зорилгоор зохион байгуулах замаар төрийн хяналт шалгалтын тогтолцоог боловсронгуй болгох | Дотоод хяналт шалгалтын чиглэлээр хийх 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд хууль тогтоомж, дүрэм журам, стандарт зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх ажлуудыг түлхүү оруулж, хэрэгжүүлэх | 2022 онд | - | Дотоод хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд урьдчилан сэргийлэх ажиллагаануудыг тусган, төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлсэн байна. | Дотоод аудитор |
| 5 | Өргөдөл, гомдол гаргах, мэдээлэл өгөх арга замыг ил тод, нээлттэй болгох, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн хугацаа түргэн шуурхай байх, шийдвэрлэлтэд хяналт тавих, мэдээлэх ажиллагааг нээлттэй болгоход анхаарч ажиллах | Өргөдөл гомдлын шийдвэрлэлтэд байнгын хяналт тавьж ажиллах, өргөдөл, гомдол гаргах болон түүнийг шийдвэрлэх явцыг ил тод болгож нийтэд мэдээлэх, | 2022 онд | - | Өргөдөл гомдол гаргах түүний шийдвэрлэлтийн явц ил тод мэдээлэгдсэн, холбогдох хяналт шалгалт хийгдсэн байна. | Захиргааны хэлтэс<br><br>Дотоод аудитор |
| 6. | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжид хөндлөнгийн үнэлгээ хийх, албан хаагчийн | Зоог үйлчилгээ, тээврийн үйлчилгээ, засвар үйлчилгээ, цэвэрлэгээ үйлчилгээний чанар, | 2022 онд | | Үйлчилгээний чанар, хүртээмжийн | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг иргэн үнэлэх тогтолцоог нэвтрүүлж, үйлчилгээг сайжруулах | хүртээмжийн судалгааг хэрэглэгчдээс улирал тутамд авч, судалгааны дүнд үндэслэн шаардлагатай арга хэмжээнүүдийг авч ажиллах | | - | судалгааг тогтмол авч, үйлчилгээний чанар, хүртээмж дээшилсэн байна. | Захиргааны хэлтэс |
| 7. | төрийн аудитын байгууллагаас хийсэн аудитын тайлан дүгнэлт, зөвлөмжийг олон нийтэд ил тод мэдээлэх тогтолцоог боловсронгуй болгож, нийтийн алба, албан тушаалтны үйл ажиллагаа, түүний үр дүнг иргэд, олон нийтийн хяналтад оруулах | Төрийн аудитын байгууллагаас үйл ажиллагаанд хийсэн шалгалтын дүгнэлт, зөвлөмжийг нээлттэй, ил тод мэдээлж байх | 2022 онд | - | Аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмж ил тод болсон байна. | Дотоод аудитор |
| | | Аудитын байгууллагын санал, зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайланг олон нийтэд ил тод мэдээлэх, цахим хуудаст байршуулах | 2022 онд | - | Тайлан мэдээ ил тод мэдээлэгдсэн байна. | |
| 8. | тендерийн үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэх | Байгууллагын 2022 оны худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулах | 2022 онд | - | Худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, тайлагнасан байна. | Захиргааны хэлтэс |
| | | Албан хаагчдыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэх суурь мэдлэг олгох сургалтад хамруулах, байгууллагын А3 сертификаттай албан хаагчдын тоог нэмэгдүүлэх | 2022 онд | 500000 | А3 сертифткаттай албан хаагчдын тоо нэмэгдсэн байна. | Захиргааны хэлтэс |
| 9. | төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд аливаа нийтлэл, нэвтрүүлэг, зар сурталчилгаа, мэдээ | Байгууллагын үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллээр сурталчлах | 2022 онд | | Байгууллагын үйл ажиллагаа олон нийтэд ил тод мэдээлэгдсэн байна. | Захиргааны хэлтэс |
| | | Dipservice.gov.mn цахим Дотоод аудитор хуудсын мэдээ | 2022 онд | - | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийг олон нийтэд хүргэхтэй холбоотой үйл ажиллагааг ил тод, нээлттэй явуулах | мэдээллийг тогтмол шинэчлэх, вэб хөгжүүлэлтийг хийх | | | | |

ХЯНАСАН: Т.УУГАНБААТАР /ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ДАРГА/

БОЛОВСРУУЛСАН: Ё.БАЯСГАЛАН /ХУУЛИЙН ЗӨВЛӨХ/ ЭБАТ